




“АУКУМО МАЙНЗ” ХХК

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГУРВАНСАЙХАН, ӨЛЗИЙТ
СУМДЫН НУТАГ
ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИХ
“БАЯН ТЭЭГИЙН ХАЙЛУУР
ЖОНШНЫ ИЛ АРГААР
АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2026
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ**



**Улаанбаатар хот
2026 он**

АГУУЛГА

ОРШИЛ	1
НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1 Төслийн товч тодорхойлолт	2
1.2 Төслийн талбайн байршил	2
1.3 Төсөл хэрэгжүүлэх хүчин чадал	4
1.4 Ил уурхайн уулын ажлын горим	4
1.5 Ил уурхайн уулын ажлын өрнөл, дараалал	4
1.6 Ил уурхайн уулын ажлын өрнөл, дараалал	5
1. 7 Төслийн эдийн засгийн үзүүлэлтүүд	5
1.8 Ухаж ачих процесс	6
1.9 Төслийн талбайн барилгажилт, бүтээн байгуулалт	6
1.10 Уурхайн шатахуун түгээх станц	7
1.11 Уурхайн гүний худаг	7
1.11.1 Усны тооцоо	8
1.12 Цахилгаан хангамж	9
1.13 Дулааны эх үүсвэр, Цахилгаан эрчим хүчний эх үүсвэр	9
1.14 Зам харилцаа, холбоо	9
1.15 Хог хаягдал	9
1.16 Төслийн газар ашиглалтын байдал	10
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	11
2.1. Төсөл хэрэгжих талбай орчмын физик, газар зүй, ландшафт	11
2.2. Цаг уур, уур амьсгал	11
2.3. Агаарын чанар	11
2.4. Геоморфологи	13
2.5. Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал	14
2.6. Ургамлын нөмрөгийн төлөв байдал	15

2.7. Амьтны аймаг.....	16
2.8. Гадаргын ус.....	18
ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ	20
3.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл.....	20
3.2 Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний арга зүй.....	20
3.3 Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ.....	21
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	24
4.2. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	27
4.3. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө	28
4.4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	28
4.5. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	29
4.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	29
4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	29
4.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	30
4.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	31
4.10. Нөлөөллийн бүсийн иргэдэд тайлагнах ажлын төлөвлөгөө	31

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Төслийн 1:70.000 масштабтай зураглалын ерөнхий харагдах байдал	3
Зураг 2.	Төслийн талбайн сансрын зураглал.....	3
Зураг 3.	Ил уурхайн ерөнхий загварчлал	5
Зураг 4.	Гүний худгийн байршил	8
Зураг 5.	Төслийн уурхайн талбайн харагдах байдал	10
Зураг 6.	Уурхайн үйл ажиллагаагаас ялгарах TSP тоосны агууламжийн тархалт,мкг/м ³	12
Зураг 7.	Уурхайн үйл ажиллагаагаас ялгарах PM10 тоосны агууламжийн тархалт,мкг/м ³	12
Зураг 8.	Уурхайн үйл ажиллагаагаас ялгарах PM2.5 тоосны агууламжийн тархалт,мкг/м ³	13
Зураг 9.	Төслийн талбайн хөрсний хэв шинэ	14
Зураг 10.	Хөрсний зүсэлт	15
Зураг 11.	Монгол орны ургамал газарзүйн тойрог.....	16

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Төслийн талбайн байршил	2
Хүснэгт 2.	Уурхайн ажиллах горим.....	4
Хүснэгт 3.	Уурхайн ажиллах горит	4
Хүснэгт 4.	Татвар, төлбөрүүд.....	6
Хүснэгт 5.	Хөхтөн амьтан	17
Хүснэгт 6.	Шувуудын олон янз байдал.....	17
Хүснэгт 7.	Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл	20
Хүснэгт 8.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	21
Хүснэгт 9.	Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	24
Хүснэгт 10.	Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ..	25
Хүснэгт 11.	Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	26
Хүснэгт 12.	Ургамал, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 26	
Хүснэгт 13.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	27
Хүснэгт 14.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	29
Хүснэгт 15.	Орчны хяналт шинжилгээний хөлөтбөр	30
Хүснэгт 16.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	31
Хүснэгт 17.	Нөлөөллийн бүсийн иргэдэд тайлагнах ажлын төлөвлөгөөний зардал.....	31
Хүснэгт 18.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн	32

ОРШИЛ

“Аукумо Майнз” ХХК-ийн “Баян тээгийн хайлуур жоншны ил аргаар ашиглах”-ийн /цаашид “Төсөл” гэх/ зориулалттай төслийн газар нь Дундговь аймгийн Өлзийт, Гурвансайхан сумын нутаг дэвсгэрт оршиж байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

“Аукумо Майнз” ХХК-ийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд болон төслийн үйл ажиллагаа, төсөл хэрэгжиж буй талбайн төлөв байдал болон төслийн талбай орчимд хийгдсэн өмнөх шинжилгээний дүнг ашиглаж, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайдын 2019-10-29-ны А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр Төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь зөвхөн төслийн ашиглалтын үйл ажиллагаанд үндэслэн хийгдсэн бөгөөд холбогдох бусад бүхий л ажиллагааг байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй нягт уялдуулан ажиллах нь зайлшгүй шаардлагатай юм.

НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн товч тодорхойлолт

Төслийн нэр: Баян тээгийн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах.

Төслийн дугаар: №12/1245

Төслийн зорилго: “Аукумо майнз” ХХК нь MV-022753 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд ашиглалтын ажлаар тогтоогдсон хайлуур жоншны нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулж, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль дүрмийн хүрээнд аюул осолгүй үйлдвэрлэл явуулах замаар үнэ цэнэ, ач холбогдлыг бий болгож, Монгол Улсын төсвийн бүрдүүлэлт, экспортын тоо хэмжээг нэмэгдүүлэн орд газрын үр өгөөж, ашгийг нэмэгдүүлэхэд энэхүү төслийн зорилго оршино.

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:

Төсөл хэрэгжүүлэгч: “Аукумо Майнз” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011751025

Регистрийн дугаар: 6322328

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 11-р хороо 7, хэсэг, 108, 16 тоот

Утас: 88114253, 99174128

1.2 Төслийн талбайн байршил


“Баян тээг” нэртэй хайлуур жоншны орд нь Улаанбаатар хотоос урагш 380 км зайд, Дундговь аймгийн Мандалговь хотоос зүүн урагш 100 км зайд байрладаг.

Төслийн талбай нь засаг захиргааны нэгжийн хуваариар Дундговь аймгийн Гурвансайхан, Өлзийт сумдын нутаг, М1:100 000-ны масштабтай байрзүйн зургийн L-48-107 тоот хавтгайд, газарзүйн дараах солбицлын цэгт байршина.

Хүснэгт 1. Төслийн талбайн байршил

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	107° 7' 1.47"	45° 15' 49.38"	6	107° 3' 32.05"	45° 16' 31.56"
2	107° 7' 1.47"	45° 15' 11.16"	7	107° 7' 1.47"	45° 16' 31.56"
3	107° 4' 30.36"	45° 15' 11.16"	8	107° 7' 1.47"	45° 16' 0.93"
4	107° 4' 30.36"	45° 15' 27.77"	9	107° 6' 46.13"	45° 15' 56.27"
5	107° 3' 32.05"	45° 15' 27.77"			

**Дундговь аймгийн Өлзийт, Гурвансайхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих
“Баян тээгийн хайлуур жоншны ил аргаар ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**



Зураг 1. Төслийн 1:70.000 масштабтай зураглалын ерөнхий харагдах байдал



1.3 Төсөл хэрэгжүүлэх хүчин чадал

“Аукумо Майнз” ХХК-ний Баян тээг нэртэй хайлуур жоншны ил аргаар ашиглах төслийн хүчин чадлыг 61.3 мян.тн хүдэр бүрэн олборлож дуусгахаар төсөлд тусгасан байна. Дээрх хүчин чадлаар ил уурхайн хүрээн дэх нөөцийг 1 жил ашиглахаар ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулжээ.

1.4 Ил уурхайн уулын ажлын горим

Ил уурхайн хүчин чадлыг сонгохдоо захиалагч талаас санал болгосон техникийн даалгавар болон ил уурхайд ажиллах техникийн хүчин чадал, баяжуулах үйлдвэрийн хүчин чадал зэргийг харгалзан үзэн 1 жилийн хугацаанд 61.3 мян.тн хүдэр бүрэн олборлож дуусгахаар тооцож төлөвлөлөө.

Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Хуанлийн	хоног	135
2	Баяр ёслол	хоног	7
3	Амралт, засвар үйлчилгээ, цаг агаар	хоног	26
4	Өвөлийн саруудын сул зогсолт	хоног	-
5	Уурхайн жилд цэвэр ажиллах хоног	хоног	102
6	Хоногт ажиллах ээлжийн үргэлжлэх хугацаа	Цаг	12
7	Ээлжийн тоо	Ш	1
8	Ээлжин дэх сул зогсолт (үдийн цай, тос түлш нэмэх)	Цаг	1
9	Ээлжийн бэлтгэл, төгсгөл	цаг	1
10	Өдрийн сул зогсолт	Цаг	2
11	Бүтээлтэй ажиллах цаг	Цаг	10
12	Цаг ашиглалт	-	0.86
13	Жилд ажиллах нийт цаг	Мот/цаг	877.20

1.5 Ил уурхайн уулын ажлын өрнөл, дараалал


Уурхай нь нийт 61.3 мян.тн жонш олборлож сийрэгжээгүйгээр 172.8 мян.м³ хөрс хуулалтын ажил хийгдэх бөгөөд үүний 3.28 мян.м³ нь шимт хөрс эзэлж байгаа бөгөөд уурхайгаас 240 м зайд уурхайн доод талд салхины нөмөр байрлалд хураахаар төсөлд тусгав. Эхний улирлын уурхайн гүнзгийрэлтийн хурд 8 м/жил байх бөгөөд уурхайн ахилтын чиглэл зүүн чиглэлтэй явагдана. Эхний улиралд гарах хөрсийг уурхайн урд овоолохоор төлөвлөсөн. Эхний улирлын хөрс хуулалтын дундаж коэффициент 2.87 м³/тн байна. Уурхайгаас олборлох жоншийг уурхайн баруун талд байрлах жоншны талбай дээр хураан овоолохоор төлөвлөсөн. Ашиглалтын 3 дахь улирлын хөрс хуулалтын дундаж коэффициент 2.09 м³/тн байна. Хөрсний гадаад овоолго 203 м урт, 115 м орчим өргөнтэй хамгийн өндөр хэсэгтээ 20 метр хүртэл өндөршилттэй ба ашиглалтын 3 дахь улиралд өсөн нэмэгдэж сийрэгжсэн байдлаар нийт 203.44 мян.м³ хөрсний гадаад овоолго үүсэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим

Ашиглалтын жил	Хүдэр олборлолт		Агуулга	Жонш хэмжээ	Кх.х	Сийрэгжсэн хөрс, мян.м ³	Жилд хийх уулын ажлын	Хөрс хуулалт, мян.м ³	Шимт хөрс, мян.м ³
	мян. м ³	мян. тн	%						
III Улирал	1.76	4.39	22.30	0.98	2.09	10.47	10.94	9.18	0.45
II Улирал	22.09	56.98	27.44	15.63	2.87	192.97	185.72	163.63	2.82
Нийт	23.85	61.37	27.07	16.61	2.48	203.44	196.66	172.81	3.28

1.6 Ил уурхайн уулын ажлын өрнөл, дараалал

Уурхай нь нийт 61.3 мян.тн жонш олборлож сийрэгжээгүйгээр 172.8 мян.м³ хөрс хуулалтын ажил хийгдэх бөгөөд үүний 3.28 мян.м³ нь шимт хөрс эзэлж байгаа бөгөөд уурхайгаас 240 м зайд уурхайн доод талд салхины нөмөр байрлалд хураахаар төсөлд тусгав. Эхний улирлын уурхайн гүнзгийрэлтийн хурд 8 м/жил байх бөгөөд уурхайн ахилтын чиглэл зүүн чиглэлтэй явагдана. Эхний улиралд гарах хөрсийг уурхайн урд овоолохоор төлөвлөсөн. Эхний улирлын хөрс хуулалтын дундаж коэффициент 2.87 м³/тн байна. Уурхайгаас олборлох жоншийг уурхайн баруун талд байрлах жоншны талбай дээр хураан овоолохоор төлөвлөсөн. Ашиглалтын 3 дахь улирлын хөрс хуулалтын дундаж коэффициент 2.09 м³/тн байна. Хөрсний гадаад овоолго 203 м урт, 115 м орчим өргөнтэй хамгийн өндөр хэсэгтээ 20 метр хүртэл өндөршилттэй ба ашиглалтын 3 дахь улиралд өсөн нэмэгдэж сийрэгжсэн байдлаар нийт 203.44 мян.м³ хөрсний гадаад овоолго үүсэхээр төлөвлөсөн.



Зураг 3. Ил уурхайн ерөнхий загварчлал

1. 7 Төслийн эдийн засгийн үзүүлэлтүүд

Монгол улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй холбогдох хууль тогтоомжийн дагуу дараах хувь хэмжээгээр тооцоолов. Энэ зардалд АМНАТөлбөр, Нэмэгдсэн өртгийн албан татвар, Аж ахуй нэгжийн орлогын албан татвар, Үл хөдлөх хөрөнгийн албан татвар, Тусгай зөвшөөрлийн төлбөр, Ус ашигласны төлбөр, Автомашин өөрөө явагч хэрэгслийн албан татвар, Автомашины агаарын бохирдлын төлбөр, Хүн амын орлогын албан татвар, Эрүүл мэндийн даатгал болон Нийгмийн даатгалын шимтгэл, Нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагт зарцуулах зардал зэрэг багтаж байгаа болно. Хайлуур жоншны чанарын ангиллаас хамааруулан борлуулах бөгөөд түүний дагуу АМНАТ төлбөрийг 5%-иар тус тооцоолсон.

Хүснэгт 4. Татвар, төлбөрүүд

№	Улсын төсөвт оруулах татвар, хураамж	сая.төг	2-р улирал
1	АМНАТ	сая.төг	170.93
2	Тусгай зөвшөөрлийн төлбөр	сая.төг	7.70
3	Уурхайн ус ашигласны төлбөр	сая.төг	11.45
4	Газар ашигласны төлбөр	сая.төг	16.99
5	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	сая.төг	0.87
6	Агаарын бохирдлын төлбөр	сая.төг	0.04
7	ХХОАТ	сая.төг	15.85
8	НДШ /Байгууллага болон хувь хүнээс нийт/	сая.төг	48.89
9	ААНОАТ	сая.төг	63.65
Нийт		сая.төг	336.36

1.8 Ухаж ачих процесс

Ухаж-ачих тоног төхөөрөмжийн сонголтыг хийхдээ ил уурхайн шаардлагатай хүчин чадлыг хангахуйц экскаваторын нийлбэр утгуурын багтаамжийг тодорхойлж боломжит хувилбаруудаас сонголт хийлээ.

Баян тээг нэртэй хайлуур жоншны ордын хөрс хуулалт болон хүдэр олборлолтонд БНСУ-д үйлдвэрлэсэн Hyundai R520 (3.2 м³ утгуурын багтаамж)-тай маркийн экскаватор ажиллах бөгөөд шаардлагатай тохиолдолд 1ш утгуур ачигч ажиллахаар бэлэн байхаар тооцсон. Хөрс болон хүдрийн доголд 57 тоннын даацтай МТ86 маркийн автосамосвал ашиглагдана. Төслийн нийт хугацаанд 175 мян.м³ хөрс хуулж 61.3 мян.тн хүдэр олборлолтын ажлыг гүйцэтгэнэ.

1.9 Төслийн талбайн барилгажилт, бүтээн байгуулалт

Төсөл хэрэгжих талбайд уурхайн захиргаа, удирдлагын байр, уурхайн хотхон, ажилчдын амрах байр, уурхайн гал тогоо, цайны газар, уурхайн ажилчдын угаалга, ариун цэврийн байр, соёл амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх байр, уурхайн засвар механикийн цех, шатахуун түгээх станц, гүний худаг, сэлбэг хэрэгсэл, бараа материалын агуулах зэрэг барилга байгууламж, бүтээн байгуулалтууд хийгдсэн байна.

1. Уурхайн хэсгийн барилга байгууламж

- Уурхайн захиргаа, удирдлагын байр
- Уурхайн хотхон /ажилчдын амрах байр, гал тогоо, цайны газар, ажилчдын угаалга, ариун цэврийн байр, соёл амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх байр/
- Уурхайн засвар механикийн цех

2. Дэд бүтэц, туслах барилга байгууламж

- Шатахуун түгээх станц
- Гүний худаг

Уурхайн барилга байгууламж

Уурхайн хотхон, ажилчдын амрах байр, цайны газар, соёл амралтын төв, уурын зуух зэрэг нь MV-022753 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн зүүн хойд хэсэгт байрлуулахаар төлөвлөсөн.

Уурхайн захиргаа, удирдлагын байр: Уурхайн захиргаа, удирдлагын байр нь уурхайн хотхонтой залгаа буюу хотхоны хашааны баруун хойд буланд байрлах ба орон нутгийн байгаль, цаг уурын нөхцөлд бүрэн тохирсон ажилтнуудын ая тухтай орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн зөөврийн орон сууцны шийдлээр уурхайн захиргаа, удирдлагын байр зэргийг хангахаар төсөлд тусгав. Уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагааны шуурхай удирдлагыг энэхүү байрнаас зохион байгуулна. Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, зааварчилга, нийтийн хурал, цуглаан, цаг үеийн шуурхай мэдээлэл зэргийг ажлын байранд явуулна.

Уурхайн гал тогоо, цайны газар: Уурхайн ажилчдыг эрүүл зөв хоол хүнсээр хангах нь маш чухал бөгөөд уурхайн гал тогоо, цайны газар нь төмөр карказ бүхий сэндвичен байр байна. Энэхүү барилга байгууламжид хүнсийг эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний агуулахыг хамтад байгуулахаар тооцсон бөгөөд мах, хүнсний ногоо, жимс жимсгэнийг зориулалтын дагуу хадгална.

Уурхайн ажилчдын угаалга, ариун цэврийн байр: Уурхайн ажилчдын хотхонд ажилчдыг эрүүл ахуйн шаардлага хангасан угаалгын газар, ариун цэврийн өрөө, халуун усны байр нь ажилчдын бүхий л ая тухтай байх шийдлийг хангасан зөөврийн контейнер байхаар тооцов.

Уурхайн засвар механикийн цех: Засвар механикийн төв нь угаах, задаргаа хийх, слесарь угсралтын хэсэг, цахилгаан ба хийн гагнуурын хэсгүүдтэй байна. Ажилчдыг цех, хэсэг, тасгуудад хуваарилахдаа аль болох уян хатан, мэргэжлийн хувьд хөрвөх бүрэн боломжтой, нэг нь нөгөөгөө орлон ажиллах чадварыг нь харгалзан үзэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл засварчид засвар механикийн цехэд засварлагдахаар ирсэн эд анги, тоног төхөөрөмжийг өргөх, тээвэрлэх ажиллагааг гүйцэтгэх чадвар, дадалтай байна. Машин, тоног төхөөрөмжийн засварын ажлын зарим хэсгийг тэдгээрийн ажлын байранд хийж гүйцэтгэхтэй холбогдуулан уурхайн засварын домкратууд, кран, өрмийн ба өнгөлөх, тэгшлэх суурь машинууд, кислород, ацителин бүхий баллонууд, цахилгаан дөш, трансформатор зэргээр тоноглогдоно.


1.10 Уурхайн шатахуун түгээх станц

ШТС нь уурхайн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй газарт байрласан байх шаардлагатай. ШТС-ын норм дүрмийн дагуу далд буюу газар ухаж байрлуулсан станц байгуулан ашиглаж байгаа ба энэхүү суурин станц нь автосамосвал болон хийн дугуйт хүнд машин механизмуудыг шатахуун түлшээр хангахад ашиглагдана. Цаг хугацаа бага зарцуулж, түлш шатахууны алдагдалгүй байлгах үүднээс уурхайн талбай дээр өндөр хүчин чадалтай шахуургатай шатахуун түргэн шахах системийг ашиглах болно. Гинжит техникүүдийн түлш шатахууныг 5 тн цистерн ашиглаж түгээх ба ШТС нь уурхайн хотхонтой ойролцоо буюу ойролцоогоор 400-500 метрийн зайд байрлана.

1.11 Уурхайн гүний худаг

“Аукумо майнз” ХХК-ний Дундговь аймгийн Гурвансайхан, Өлзийт сумдын нутагт, хэрэгжих “Баян тээг хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах” төслийн усны хэрэглээг ашиглалтын талбайтай ойролцоо байрлах гүний худгийн усаар хангах юм. Энэхүү худагтай гэрээ байгуулан ажиллана.

Уурхайн ажилчдын унд ахуй хэрэглээний усыг гүний худгаас хангаж ажиллах бөгөөд төслийн талбайн баруун талд гүний худаг гаргаж ашиглахаар төлөвлөж байна. Уурхайд байрлан ажиллах ажилчдын ундын усны хэрэглээг хоногт 150 литр/хүн байхаар тооцож дулааны улиралд шаардлагатай тохиолдолд замын тоосжилт дарах зорилгоор 1 км² талбайд 6 литр ус зарцуулахаар тооцов.



Зураг 4. Гүний худгийн байршил

1.12 Усны тооцоо

Уурхайн тоосжилт дарах усны тооцоо:

Тоосжилт бууруулах усны хэрэглээг тус журмын 13-р хавсралтын 7-д заасны дагуу 1 м²-д 2 л-р тооцож авав. Замын нийт замын урт 1000 м бөгөөд өргөнийг 30 м-р тооцвол 30 000 м² болж байна. Орон нутгийн уур амьсгал, замын хөдөлгөөний эрчим, тухайн замын тоосжилтын байдлаас хамааран замын тоос дарах ажлыг 4-10 сард буюу дулааны улиралд явуулах бөгөөд 210 хоног болно.

Ил уурхайн зам талбайн усалгаанд шаардлагатай усыг тооцоход

$$240 \text{ м} * 30 \text{ м} * 2 \text{ л} = 14.4 \text{ м}^3/\text{хон} * 102 \text{ хон} = 1468.8 \text{ м}^3/\text{жил}$$

Уурхайн зам талбайн тоосжилтыг дарах усны эх үүсвэр нь гүний усны гадна хурын усыг хуримтлуулах замаар хангана.

Хүн амын усны хэрэглээ:

Уурхайн жилд ажиллах хугацааг ТЭЗҮ-д тусгасны дагуу ажилчдын ажиллах хугацааг 102 хоног, ажилчдын тоог 49 хүн гэж авав. Ажилчдын ахуйн усны хэрэглээг А/301-р тушаалын 14-р хавсралтын 31-т заасны дагуу /албан байгууллагад/ 1 хүн 1 хоногт 80 л-р тооцож авав.

$49 \text{ хүн} * 80 \text{ л} = 3.92 \text{ м}^3/\text{хоног} * 102 \text{ хон} = 399.84 \text{ м}^3/\text{жил}$

Усны эх үүсвэр нь өөрсдийн талбайд гүний худаг гаргаж ашиглаж байна. Ундарга 2.0 л/с

Ногоон байгууламжийн усалгаанд шаардагдах усны тооцоо:

$200 \text{ м}^2 * 4 \text{ л} = 0.8 \text{ м}^3/\text{хон} * 16 \text{ удаа} = 12.8 \text{ м}^3/\text{жил}$

Мод суулгац $100 \text{ ш} * 40 \text{ л} = 4 \text{ м}^3/\text{хон} * 60 \text{ удаа} = 240 \text{ м}^3/\text{жил}$.

1.13 Цахилгаан хангамж

Баян тээгийн хайлуур жоншны ордыг 1 жилийн хугацаанд ашиглалт явуулах ба төслийн хугацаанд цахилгааны хэрэглэгч нь уурхай хотхон, удирдлагын байр, гүний худаг зэрэг юм. Тухайн төсөл маань харьцангуй богино хугацаанд үргэлжлэх бөгөөд цахилгаан хангамжийг Т7676-98 маркийн дизель станц байхаар төлөвлөж төсөлд тусгав.

1.14 Дулааны эх үүсвэр, Цахилгаан эрчим хүчний эх үүсвэр

Баян тээгийн хайлуур жоншны ордыг 2 улирлын хугацаанд ашиглалт явуулах ба төслийн хугацаанд цахилгааны хэрэглэгч нь уурхай хотхон, удирдлагын байр, гүний худаг зэрэг юм. Тухайн төсөл маань харьцангуй богино хугацаанд үргэлжлэх бөгөөд цахилгаан хангамжийг Т7676-98 маркийн дизель станц байхаар төлөвлөж төсөлд тусгасан.

1.15 Зам харилцаа, холбоо

Баян тээг хүдрийн орд газар нь Улаанбаатар хотоос 380 км зайтай байрладаг бөгөөд зам, тээвэр, хот байгуулалтын сайдын баталсан маршрутын дагуу уурхайгаас олборлосон хүдрийг авто тээврээр Чойр өртөө хүртэл тээвэрлэх бөгөөд 1 удаагийн тээвэрлэлтээр 65 тн-ыг зөөвөрлөхөөр тусгаж, тээврийн машины ресс тутамд 100.0 мян.төгрөгийн зам арчилгааны зардал гарахаар тооцож, зардлыг төслийн тооцоололд тусгасан.

1.16 Хог хаягдал

Уурхай ашиглалтын үйл ажиллагаа явуулахтай холбогдон ажилчдын хоолны газар, контор, ахуй үйлчилгээний комбинат, үйлдвэрийн цех хэсгүүдээс үйлдвэрлэлийн болон ахуйн хатуу, шингэн хог хаягдал гардаг. Эдгээр хог хаягдлын ихэнх нь энгийн хог хаягдал бөгөөд эргэн ашиглагдах хог хаягдлууд мөн байна.

Уурхайн хатуу хог хаягдал:

2024 онд батлагдсан ТЭЗҮ-д хайлуур жоншний хаягдлыг 3.95%, бохирдлыг 3.16 % байхаар тооцсон байна.

Ахуйн хатуу хог хаягдал

Ахуйн хаягдал: Төслийн үйл ажиллагаанд нийт 49 хүн ажиллах ба тэдний ахуйн гаралтай хатуу хог хаягдлын хэмжээг тооцохдоо нэг хүнээс хоногт 0.6^1 кг хог хаягдал гарна гэдэг жишиг

хэмжээг үндэслэн тооцоход 29.4 кг (49 x 0.6 кг) буюу 1 сард 30 хон х 882кг = 0.88 тн орчим хатуу хог хаягдал гарахаар байна.

Шингэн хог хаягдал

Бохир ус зөвхөн ахуйн хэрэглээнээс гарах бөгөөд хэрэглээний усны 80 хувиар тооцож авав. Хоногт 3.13 м³, жилд 319.7 м³ ахуйн бохир ус гарна. Энэхүү бохир усыг цэвэршүүлэх байгууламж суурилуулан цэвэршүүлж ногоон байгууламж, зам талбайн усалгаанд хэрэглэж болно.

Хийн хаягдал

Орчин үед агаар мандалд ялгарч буй хүлэмжийн хийг бууруулах, байгаль орчны бохирдлыг бууруулах асуудал дэлхий нийтийн чухал асуудал болоод байгаа өнөө үед утааны хий дэх үнс нурам, хортой хийнүүдийн нэгдлийг заавал шүүж норм хэмжээнд байлгах шаардлагатай байна.

Хатуу хог хаягдлыг зайлуулах систем

Уурхайн болон ахуйн үйл ажиллагааны явцад үүссэн хог хаягдлуудыг сумтай болон бусад хог хаягдал боловсруулах компаниудтай гэрээлэн зохих журмын дагуу зайлуулах болно.

1.17 Төслийн газар ашиглалтын байдал

Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн Дундговь аймгийн Гурвансайхан, Өлзийт сумдын Баян тээг нэртэй газарт 1061.95 гектар талбайг хамарсан ашиглалтын талбайд хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг зөвшөөрч улсын бүртгэлийн 9011751025 тоот гэрчилгээтэй “Аукумо майнз” ХХК-д тусгай зөвшөөрлийг АМГТГ-с 2054 оны 02 сарын 05 өдөр хүртэл олгосон байна.



Зураг 5. Төслийн уурхайн талбайн харагдах байдал

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Төсөл хэрэгжих талбай орчмын физик, газар зүй, ландшафт

Дундговь аймаг нь Монгол орны физик-газарзүйн мужлалаар Говийн их мужийн Алтайн ар говийн мужийн Нууруудын хөндий тойрог, Хангайн өмнөд бэгэлцэгийн тойрог, Дорнод говийн мужийн Умарт талын гүвээт талын тойрог, Монголын Дорнод талын их мужийн Халхын Дундад ба Дарьгангын талархаг мужийн Ухаа Гүвээт Халхын дундад тал тойрогт багтаж байна. Дундговь аймгийн газар нутгийн хотгор гүдгэрийг ерөнхий төрх байдал, гарал үүслийн үүднээс авч үзэхэд цав толгод болон ухаа гүвээт тал гэсэн хэв шинжид багтана. Дундговь аймгийн өндөржилт нь далайн түвшинээс дээш 1100-1350 метрт өргөгдсөн, нутгийн хамгийн өндөр цэг нь 1926 м өндөрт орших Дэлгэрхангай уул бөгөөд Их, Бага газрын чулуу зэрэг уулс бий.


2.2. Цаг уур, уур амьсгал

Дундговь аймгийн нутаг дэвсгэр нь уур амьсгалын хувьд хуурай, сэрүүн, уулын хээрийн муж /Эрдэнэдалайн хойд хэсэг, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэнгийн хойд хэсэг/, нэн хуурай дулаавтар, цөлөрхөг хээрийн муж /Дэлгэрхангай, Хулд, Луус, Гурвансайхан, Өндөршил сумын хойд хэсэг, Сайхан-Овоо, Сайнцагаан, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Баянжаргалан сумдын нутаг/, нэн хуурай дулаан, цөлөрхөг хээрийн муж /Дэлгэрхангай, Хулд, Гурвансайхан сумдын урд хэсэг, Өлзийт сумын нутаг/ гэж 3 хуваадаг. Агаарын температурын дундаж хэмжээ өвлийн сард – 16-19 градус, зуны сард +17-21 градус, жилд орох хур тундасны хэмжээ 95-150 мм унадаг.


2.3. Агаарын чанар

Ордын үйл ажилгаанаас үүсэх үндсэн агаар бохирдуулагчид болох тоос, тоосонцрын ялгарлын орон зайн тархалтын хэмжээг эх үүсвэрийн тооцоолол, цаг уурын үзүүлэлтүүд болон газрын гадаргын өндөршлийн төлөвийг ашиглан тооцов. Ордын хувьд жилийн турш олборлолтын үйл ажиллагаа явагддаг тул тархалтын загварын үр дүнг Монгол улсын гадаад орчны агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага болох MNS 4585:2025 стандартын жилийн дундаж хүлцэх хэмжээтэй харьцуулав. Төслийн зүгээс агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн хүрээг агаарт хамгийн ихээр ялгаруулж байгаа агаар бохирдуулагч бодисын агаарын чанарын стандартын хүлцэх хэмжээнээс давсан бохирдолтой хэсгээр зааглан тогтоов.


Уурхайн олборлолт, тээвэрлэлт болон бусад үйл ажиллагаа. Ордын олборлох тээвэрлэх үйл ажиллагаанаас ялгарах нийт тоосны агууламж олборлолт хийгдэж байгаа бүсийн дундаж агууламж 25 мкг/м³, PM10 тоосонцрын агууламж 8 мкг/м³, PM2.5 тоосны агууламж 2 мкг/м³ орчны агууламжийг нэмэгдүүлнэ байна. Төслөөс орчны агаарын чанарт нөлөөллөх нөлөөллөл бага байна.



Зураг 6. Уурхайн үйл ажиллагаагаас ялгарах TSP тоосны агууламжийн тархалт, $\text{мкг}/\text{м}^3$



Зураг 7. Уурхайн үйл ажиллагаагаас ялгарах PM10 тоосны агууламжийн тархалт, $\text{мкг}/\text{м}^3$



Зураг 8. Уурхайн үйл ажиллагаагаас ялгарах PM2.5 тоосны агууламжийн тархалт, мкг/м³

2.4. Геоморфологи

Дундговь аймаг нь геоморфологийн ангиллаар Дорнод Монголын талын мужид хамаарагдана /Мурзаев (1952), Селиванов (1972), Сырнев (1982).

Төслийн талбайд гадаргуугийн элэгдлийн, элэгдэл-тектоникийн, галт уулын гаралтай, хуримтлалын гэсэн гарал үүслийн төрлүүдийг ялгаж байна. Гадаргуугийн гарал үүслийн төрөл тус бүр нь өөртөө тодорхой дүрс хэлбэрийн төрлүүдийг багтааж байдаг.

Элэгдлийн гадаргуу:

Элэгдлийн гадарга нь судалгааны талбайд доор дурдсан дүрс хэлбэрүүдийг өгүүлж байна. Үүнд :

1. Тэгширлийн гадаргуугийн үлдмэл талбайнууд
2. Суурь чулуулагт үүссэн элэгдлийн довжоот тал
3. Дунд ба шинэ төрмөлийн тунамал хурдаст үүссэн давхаргат тал


Тэгширлийн гадаргуугийн талбайнууд нь эрэл-зураглалын талбайн ихээхэн хэсэгт тархсан бөгөөд эдгээр нь нутгийн геологийн түүхэн хөгжлийн явцад дотоод (эндоген) гадаад (экзоген) хүчний нөлөөгөөр хэлбэр дүрсээ өөрчилж орчин үеийн янз бүрийн дүрс хэлбэрүүдийг үүсгэж байна.

Үндсэн чулуулагт үүссэн довжоот тал, дунд, шинэ төрмөл тунамал хурдаст үүссэн давхаргат талууд нь нутгийн платформын хөгжлийн үед үүссэн тэгш талын (пенеплен) хэсгүүд бөгөөд энэ нь гагцхүү оршин тогтнох хугацаанд дээрх хүчин зүйлүүдийн нөлөөгөөр анхны дүрс

хэлбэрээ өөрчлөн орчин үеийн гадаргын хэлбэрүүдийг үүсгэжээ. Платформ хөгжлийн үед үүссэн тэгш талын зарим хэсэг нь хэлбэр дүрсээ өөрчлөлгүйгээр орчин үеийн гадаргуу хадгалагдан үлдсэн байна. Эдгээрийг бид хадгалагдан үлдсэн тэгшрэлийн гадаргуугийн үлдмэл талбай гэж ялгалаа. Гэхдээ эдгээр ялгасан талбайнууд нь неотектоникийн хөдөлгөөнөөр янз бүрийн түвшинд өргөгдсөн ба суусан байдалтай ажиглагдана.

2.5. Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал

Төслийн талбайн хөрсний хэв шинжийн байрзүйн зургийг доорх зурагт үзүүллээ.



Зураг 9. Төслийн талбайн хөрсний хэв шинэ

Талбайн төрх байдал. Хөрсний өнгөн гадарга, элсэн хучаасгүй, ургамалан нөмрөггүй бараг нүцгэн, ургамал дөнгөж ургаж байгаа, 1 кв/м талбайд 2-3 ш ургамалтай, түүний өндөр 3-6 см, зонхилох ургамал нь монгол сонгино (*Allium mongolicum*), сайрын хялгана, (*stipa glareosa*), хазаар өвс (*Cleistogenes songorica*), үслэг манан хамхаг (*Bassia dasyphylla*) зэрэг зүйлийн ургамлууд зонхилж, *Salsola collina* (Толгодын Бударгана), *Kochia prostrata* (Дэлхээ Тогторгон), *Setaria viridis* (Ногоон хоног будаа), *Tribulus terrestris*, *Caragana leucophloea* (Алтан харгана), *Scorzonera divaricata* (Дэрэвгэр хавьсхана) зүйлийн ургамлууд цөөн тоотой тохиолдоно. Говийн нам уулс, унаа гүвээ толгодын хоорондох хөндийн бор хөрс, далайн түвшнээс дээш 1220-1230 м өндөрт делювийн карбонатлаг хурдас дээр үүснэ.

Энэ хөрсийг төлөөлүүлж 2-р зүсэлтийг 2-р зүсэлтийг лиценцийн талбайн зүүн урд бэлчээрийн эдэлбэрт хийв.


2-р зүсэлтийн байршил: N = 45° 17'37,76 E = 107° 2,44,18" H = 1171,0 м Энэ хөрсний морфологи бичиглэл, лабораторийн шижилгээний дүн, шим тэжээлийн бодисын агууламжийг авч үзв

А-0-10 см. Гандмал бор өнгөтэй чийггүй хуурай, элсэнцэр, том бөөмөн бүтэцтэй, дараагийн үе рүү өнгөөрэй аажим шилжиж орно.

Вса-10-27 см. Цайдардуу бор, ургамлын үндэс бараг байхгүй, хуурайвтар, том бөөмөн бүтэцтэй, хөрсний зүсэлтийн хананд карбонатын давсны толбуудтай, элсэнцэр механик бүтэцтэй дараагийн үе рүү шилжихдээ аажим шилжинэ.

ВС-27-46 см. Цагаан цайвар шаргал өнгөтэй ургамлын үндэсгүй, өлөн чийгтэй, элсэнцэр, хэврэг бөөмөн бүтэцтэй байна.

2-р зүсэлтээс үзвэл ялзмагийн агууламж дээд үедээ 1,16 %, хөрсний орчин 8,50-8,65 буюу сул шүлтлэг, 100 гр хөрсөнд хуримтлагдах шингээгдсэн сууриудийн нийлбэр 11,8-17,4 мг/экв байгаагийн дийлэнх хувийг кальци магнигаас 6,5 дахин их, хөдөлгөөнт фосфор 1,40 мг, солтлох калий 52,0 мг, хөрсний цахилгаан дамжуулалтаар хөрсөнд агуулагдаж байгаа хортой давсыг тодорхойлоход амьд амьтанд сөргөөр нөлөөлөх давс илрээгүй. Говийн нам уулс, ухаа гүвээ толгодын бор хөрс, нам уулсын хоорондох хөндийн хөрсний урвалын орчин рН ерөнхийдөө сул шүлтлэг, ялзмагийн агууламж ойролцоо 1%, шингээгдсэн сууриудын кальцийн катион давамгайлна. Ерөнхийд нь дүгнэж үзэхэд хөрсний шим тэжээлийн бодис, гарал үүслээрэй адил байна.



Зураг 10. Хөрсний зүсэлт

2.6. Ургамлын нөмрөгийн төлөв байдал

Монголын нэрт ургамал судлаач, академич Н.Өлзийхутаг “Монгол орны ургамлын аймгийн тойм” (1982) бүтээлдээ тус сумын нутгийг Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамруулан авч үзсэн байдаг (Өлзийхутаг, 1982).

Цөлөрхөг хээрийн бүсэд жилдээ ихэвчлэн 100-120 мм тунадас унадаг. Цөлөрхөг хээрийн ургамлыг экологийн бүлэгт хамаарах байдлаар нь авч үзвэл хуурайсаг – 21.4 %, чийгсүү-хуурайсаг– 10.2 %, хуурайсуу-чулуусаг– 21.8 %, чийгсүү-давссаг – 15.4 %, хуурайсаг-элссэг – 6.5 %, давамагайлна. Давссаг бүлгийн ургамлууд нэлээд бүсдэх бүх ургамлын 22.2 %-ийг эзэлж байна. Жишээ нь: Таана, Хөмөл, Шарбударгана, Хотир зонхилон ургана.



Зураг 11. Монгол орны ургамал газарзүйн тойрог

Монголын нэрт ургамал судлаач, академич Н.Өлзийхутаг “Монгол орны ургамлын аймгийн тойм” (1982) бүтээлдээ тус сумын нутгийг Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамруулан авч үзсэн байдаг (Өлзийхутаг, 1982).

Цөлөрхөг хээрийн бүсэд жилдээ ихэвчлэн 100-120 мм тунадас унадаг. Цөлөрхөг хээрийн ургамлыг экологийн бүлэгт хамаарах байдлаар нь авч үзвэл хуурайсаг – 21.4 %, чийгсүү-хуурайсаг– 10.2 %, хуурайсуу-чулуусаг– 21.8 %, чийгсүү-давссаг – 15.4 %, хуурайсаг-элссэг – 6.5 %, давамагайлна. Давссаг бүлгийн ургамлууд нэлээд бүсдэх бүх ургамлын 22.2 %-ийг эзэлж байна. Жишээ нь: Таана, Хөмөл, Шарбударгана, Хотир зонхилон ургана.

2.7. Амьтны аймаг

ХӨХТӨН: Ашиглалтын талбайд задгай ус байхгүй, нэг төрлийн талархаг орчин давамгай байх тул зүйлийн олон янз байдал, ялангуяа том хөхтөн цөөн. Зөвхөн цас орсон тохиолдолд Үл олдохын тал, хөндийгөөр цагаан зээр олноор байрших боломжтой.

Төслийн талбайд шавьж идэштэнээс говь нутагт түгээмэл тохиолдох дэлдэн зараа, далавчтанаас умрын турсаахай, тоом соотгой, сахалт багваахай, мэрэгчтнээс орог зузга, цомч шишүүхэй, хадны барагчин, хул чичүүл, шар чичүүл, шивэр алагдаага тархан нутаглаж байна.

Саарал чоно хааяа гүйдлээр үзэгдэнэ. Харин сүүлийн жилүүдэд энэ орчимд хоёрч удаа үнэг галзуурсан байна. Өнгөрсөн хавар шуурганд үхсэн малын сэг зэм хаа сайгүй байгаа нь гэрийн

мал болон бусад зэрлэг амьтдыг өвчлүүлэх нэг шалтгаан байж болох юм. Ашиглалтын талбайн хүрээнд Зэрлэг амьтан ургамлын зүйлүүдийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенци CITES–д мануул мий орсон.

Одоогоор тус бүс нутгийн хөхт амьтдын тоо толгой, тархалт харьцангуй хэвийн байна. Тухайн нутгийн хөхтөн амьтдын зүйлийн олон янз байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 5. Хөхтөн амьтан

№	Зүйл (монгол, латин, англи)			1	2	3	4
1	Дэлдэн зараа	<i>Hemiechinus auritus</i>	Long-eared hedgehog				
2	Сахалт багваахай	<i>Myotis mystacinus</i>	Whiskered bat			+	
3	Том соотгой	<i>Plecotus austriacus</i>	Grey long-eared bat			+	
4	Буурал сармаахай	<i>Vespertilio murinus</i>	Particol(u) red bat			+	
5	Говьсог сарсаахай	<i>Eptesicus gobiensis</i>	Gobi desert bat			+	
6	Боролзон туулай	<i>Lepus tolai</i>	Tolai hare			+	
7	Орог зузга	<i>Phodopus campbelli</i>	Dwarf hamster				
8	Цомч шишүүхэй	<i>Allocricetulus curtatus</i>	Mongolian hamster				
9	Хул чичүүл	<i>Meriones unguiculatus</i>	Mongolian gerbil				
10.	Шаргал чичүүл	<i>Meriones meridianus</i>	Mid day gerbil				
11	Морин цөцүүл	<i>Rhombomys opimus</i>	Great gerbil				
12	Шивэр алагдаага	<i>Allactaga sibirica</i>	Siberian jerboa				
13	Шар үнэг	<i>Vulpes vulpes</i>	Common fox				+
14	Хярс үнэг	<i>Vulpes corsac</i>	Corsac fox				+
15	Мануул мий	<i>Otocolobus manul</i>	Manul cat		+		+
16	Цагаан зээр	<i>Procapra gutturosa</i>	Mongolian gazelle			+	+

а) Монгол улсын улаан ном, ховор амьтны жагсаалт (1), Олон улсын худалдааны конвенци (2), Нүүдэллэдэг амьтны зүйлийг хамгаалах конвенцид (3) орсон болон агнуурын холбогдолтой (4) зүйл

ШУВУУ: Төслийн талбайд 20-н зүйлийн шувуу тэмдэглэгдсэн. Энд монгол болжмор, адууч чогчоохой, бүжимч чогчоохой, шоорон алаг болжмор, хээрийн бор шувуу, оронгийн бор шувуу, хадны бор шувуу, үнсэн дунхай, хар хэрээ, хөхвөр тагтаа, ногтруу, шилийн сар, сохор элээ, өвөгт тогоруу, агнуурын шувуудаас хахилаг, хадны тагтаа, ногтруу тохиолдоно.

Хүснэгт 6. Шувуудын олон янз байдал

№	Шувуудын нэрс			Орших хэлбэрийн хувьд						
	Монгол	Латин	Англи	Суурин	Нүүдлийн	Өндөглөг	Дайрч өнгөрдөг	Тохиолдлын	Өвөл ирдэг	Өндөглөг
1	Сохор элээ	<i>Milvus migrans</i>	Black Kite		+	+				
2	Шилийн сар	<i>Buteo hemilasius</i>	Upland Buzzard or Hawk	+		+				
3	Тарважи бүргэд	<i>Aquila rapax</i>	Steppe Eagle	+		+				
4	Тас	<i>Aegypius monachus</i>	Cinereous or Black Vulture	+		+				
5	Хадны тагтаа	<i>Columba rupestris</i>	Blue Hill Pigeon	+		+				
6	Ногтруу	<i>Syrhaptes paradoxus</i>	Sandgrouse	+		+				

7	Хотны бүгээхэй	<i>Athene noctua</i>	Little Owl	+		+				
8	Өвөөлж	<i>Upupa epops</i>	Hoopoe		+	+				
9	Боролзой болжмор	<i>Alauda arvensis</i>	Northern or Common Skylark		+	+				
10	Хээрийн шийхнүүхэй	<i>Anthus richardi</i>	Richard's Pipit		+	+				
11	Үнсэн дунхай	<i>Lanius excubitor</i>	Great grey shrike		+	+				
12	Хар хэрээ	<i>Corvus corone</i>	Carrion or hooded crow	+		+				
13	Хон хэрээ	<i>Corvus corax</i>	Northern Raven	+		+				
14	Шаазгай	<i>pica pica</i>	Magpie	+		+				
15	Улаан хошуут	<i>Pyrhocorax pyrrhocorax</i>	Chough	+		+				
16	Адууч чогчоохой	<i>Oenanthe oenanthe</i>	Northern Wheatear		+	+				
17	Бүжимч чогчоохой	<i>Oenanthe isabellina</i>	Isabelline Wheatear		+	+				
18	Цөлийн чогчоохой	<i>Oenanthe deserti</i>	Desert wheatear		+	+				
19	Оронгийн бор шувуу	<i>Passer domesticus</i>	House Sparrow	+		+				
20	Хээрийн бор шувуу	<i>Passer montanus</i>	Tree Sparrow	+		+				

МӨЛХӨГЧИД: Судалгааны талбайд цоохор хонин гүрвэл, могой гүрвэл бий. Харин могой тэмдэглэгдээгүй.

Ашиглалтын талбайн хүрээнд авч үзвэл одоогоор ямар нэг ховордлын статус бүхий хүйтэн цустан алга байна.

2.8. Гадаргын ус

Усан сүлжээний хувьд талбайн хэмжээнд усан сүлжээ дунд зэрэг хөгжсөн бөгөөд Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг. Ханын гол, Бадрахын гол, Үхэр чулуутын гол булаг, Ямаадайн булаг, Баян уулын булаг зэрэг нэлээд тооны булгуудтай ба тэдгээр нь тухайн жилийн хур тунадасны хэмжээнээс хамаарч тасалддаг. Цайдмын нуур, Хайртын нуур зэрэг хэд хэдэн жижиг давстай нууруудтай бөгөөд тухайн жилийн хур тунадасны хэмжээнээс хамаарч усны горим нь хувирамтгай, зарим үед хатаж ширгэсэн байдаг.

Газрын доорх ус:

Гидрогеологийн мужлалаар улирлын хомс хангалттай, Дорноговийн мужид багтана. Шинэ төрмөлийн үеийн бялхмал чулуулгийн нэгэн хэлбэр шүлтлэг хүрмэн чулуулагт агуулагддаг газрын гүний ус нь ерөнхийдөө эрдэсжилт ихтэй байдаг. Газрын доорх усны нөөц жигд бус тархалттай Газрын доорх усны нөөц бүрэлдэх процесст хур тунадас, усны уурын өтгөрөл, тектоник хагарлын тогтоц, ялангуяа бүс нутгийн шинжтэй томоохон хагарал нөлөө үзүүлнэ.

Газрын доорх усны их баялаг нөөц нь голын хөндийн аллюви, пролювийн хурдас болон томоохон хотгор газарт тархсан Цэрдийн галавын настай сэвсгэрдүү хурдас, тектоник хагарлын зарим хэсэгт хуримтлагдсан байна.

Газрын доорх усны чанар

Дундговь аймгийн Гурвансайхан сумдын нутаг дэвсгэрт газрын доорх усны нөөц харьцангуй их биш, ихэвчлэн дээд талын зузаан шаварлаг үеүдийг нэвтлэн гарч боломжтой уст үед хүрэхэд дундажаар 100 м –ээс дээш өрөмддөг учир дээрх аймгуудын гүн өрмийн худгийн тоо бага, нөгөө талаар усны чанарын асуудлын хувьд эрдэсжилт ихтэй байдаг нь газрын доорхи усыг агуулж байгаа хурдас чулуулгийн бүтэцтэй холбоотой байдаг учир уст үеийг бүрдүүлж байгаа цэрдийн галавын хурдасууд учир эрдэсжилт зарим газартаа харьцангуй их давсархаг найрлагатай байна. Газрын доорхи усыг орших байдлаар нь өнгөн хөрсний, ул хөрсний, артезийн гэж ангилан үздэг бөгөөд өнгөн хөрсний ус газрын гадаргад ойр байдаг учраас цаг агаар, хур тунадас зэрэг гадаад орчны нөлөөллөөс шалтгаалан амархан хувирч байдгаас гадна усны түвшин нь улирал бүр харилцан адилгүй байдаг.

Газрын доорх усны гидрогеохимийн өөрчлөлтийн хувьд Чойроос Замын-Үүд рүүгээ чиглэсэн усны эрдэсжилт нэмэгдэж найрлагын хувьд гидрокарбонатаас хлорын ангид шилжиж байна. Гадаргуугаас доошлох тутам өөрөөр хэлбэл бэл хормойгоос доошилж хонхор хотост ойртох тусам гидрокарбонатаас сульфатад улмаар хлоридод шилжих, катионы хувьд кальцаас магни натрид шилжиж байгаа нь өөрчлөгдөж хлор ба натрийн ион зонхилох хандлага ажиглагдаж байна. Ер нь Говийн бүсийн газрын доорх усны эрдэсжилт нэмэгдэх тутам хлор сульфатын ион эрс нэмэгддэг байна.

Дээрх сумдын нутагт байрлах талбайнуудын хувьд газрын доорх усны чөлөөт солилцооны бүсэд бүрэлдэж байгаа бага гүнээс илэрсэн усыг өргөн олборлож (уурхайн ба богино яндант, гар худаг) ашигладаг тул түүний химийн найрлагыг бүс нутгийн хэмжээгээр байгалийн унаган төрх байдлыг судлах, хүн амын болон үйлдвэрлэл, бэлчээрийн зориулалтаар хэрэглэх усны чанар найрлагад үнэлгээ өгч, чанар хангахгүй усыг сайжруулах арга хэмжээг авах, эрдэсжилт хатуулаг ихтэй усыг цэнгэгжүүлэх зөөлрүүлэх замаар зөв зохистой ашиглах замыг амьдралд нэвтрүүлэх боломжтой юм.

.

ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Энэ бүлэгт төслөөс байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг нөлөөлөлд өртөх орчноор буюу газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, гадаргын болон гүний ус, хөрсөн бүрхэвч, ургамлын аймаг, амьтны аймаг, түүх соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэнд зэрэг чиглэлүүдээр авч үзэн тодорхойлж, тэдгээр нөлөөллийн эрчим, цар хүрээг үнэлэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгасан болно.

3.2 Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний арга зүй

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А/117 дугаар тушаалын 2 дүгээр хавсралт, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх шинэчилсэн аргачлал болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2017 оны 12 сарын 31-ны өдрийн А/331 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ.

Төслийн үйл ажиллагаанаас үүдэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажлыг зохион байгуулахын тулд нөлөөллийн хэмжээг тодорхойлно. Нөлөөллийн хэмжээг тодорхойлох нь тухайн хүний ойлголтоос ихээхэн хамаардаг тул ихэнх тохиолдолд байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр дараах шаардлагыг мөрдөх шаардлагатай. Нөлөөллийн хэмжээг 3 хүчин зүйлээр тодорхойлно. Нөлөөлөл тус бүрд дээр дурдсан хүчин зүйл бүр 1, 2, 3 гэсэн үнэлгээ өгөх бөгөөд энэ нь тухайн нөлөөллийн хэмжээ, тархалт, давтамжийг харуулна. Үүнд: Нөлөөллийн хэмжээ, хугацаа, нөлөөлөлд өртөх газар нутаг, нөлөөлөл тохиолдох, давтагдах магадлал.

Хүснэгт 7. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Нөлөөллийн төрөл	Эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал	Нийт оноо	Онооны эзлэх хувь %	Нөлөөллийн зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт							
Гадаргын усны чанарын өөрчлөлт	0	0	0	0	0	0	
Газрын доорх усны нөөц, чанар	6	2	1	2	11	44	M
Агаарын орчин /бохирдол/	4	2	1	3	10	40	M
Хөрсний элэгдэл, эвдрэл	4	2	1	2	9	36	M
Ургамлын төрөл зүйлийн өөрчлөлт	2	2	1	2	7	28	L
Зэрлэг, ан амьтдын орон зайн өөрчлөлт	2	2	1	2	7	28	L
Геологийн тогтцын өөрчлөлт	4	2	1	2	9	36	M
Дундаж						35.3	M
2. Байгалийн нөөцийн ашиглалт							
Газрын гадаргын нөөц баялаг	2	2	1	2	7	28	L
Бэлчээр, тэжээлийн байдал	2	2	1	2	7	28	L
Эрдэс түүхий эдийн нөөц	8	2	1	4	15	60	M
Дундаж						38.6	M
3. Байгаль орчны өөрчлөлт							

**Дундговь аймгийн Өлзийт, Гурвансайхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих
“Баян тээгийн хайлуур жоншны ил аргаар ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Нөлөөллийн төрөл	Эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал	Нийт оноо	Онооны эзлэх хувь %	Нөлөөллийн зэрэг
Ундны усны чанар, хэмжээ	2	2	1	3	7	28	L
Хөрсний бохирдол	4	2	1	2	9	36	M
Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	4	1	1	3	9	36	M
Агаар орчны тоосжилт үүсэх	8	2	1	4	15	60	M
Дундаж						40	M
4. Нийгэм, дэд бүтцийн салбарын өөрчлөлт							
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	6	2	1	4	13	52	M
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх	6	2	2	3	13	52	M
Дундаж						52	M
5. Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл,соёлт давхаргад үзүүлэх нөлөөлөл							
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	4	2	1	2	9	36	M
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	4	2	1	2	9	36	M
Тусгай хамгаалалтай ба цогцолбор газарт нөлөөлөх	2	1	1	1	5	20	L
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	2	2	1	2	7	28	L
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх	2	2	1	2	7	28	L
Дундаж						29.6	L
6. Бусад нөлөөлөл							
Хүчтэй салхи, түймэр газар хөдлөл, аянга	2	1	1	2	6	24	L
Хог хаягдлын нөлөөлөл үүсэх	4	2	1	3	10	40	M
Дундаж						32	M
Үр дүн /ерөнхий дундаж/						37.9	M

3.3 Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Үзүүлэх	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх
Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	➢ Тухайн жилийн БОМТ-н БОХТ, БОХШХ-т тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлж, тоос болон бусад хийн хэмжилтийг хийж, тухайн орчны агаарын бохирдолтыг хянаж байх. Төслийн бүхий л үйл ажиллагааны явцад тоосжилтыг хянах бууруулах үр ашигтай бөгөөд практик ач холбогдолтой үйл ажиллагааны журмыг боловсруулан мөрдөх, ➢ Тээврийн хэрэгслийн янданд шүүлтүүр тавих, төслийн үйл ажиллагаанд ашиглах машины техникийн оношилгоо, тохиргоо, үйлчилгээг тогтмол хийж, ашиглалтын нөхцөлийг сайжруулах замаар агаарын бохирдлыг багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай ➢ Хатуу хог хаягдлыг тогтмол ачуулж, төслийн талбайд удаан хадгалахгүй байх ➢ Зориулалтын замаас гадуур өөр зам гаргахгүй байх тал дээр анхаарах ➢ Хэт халалт, агаарын бохирдол тоосжилтыг бага байлгахын тулд ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх
Дуу чимээ, чичиргээнээс үзүүлэх	➢ Авто машины дуут дохиог гэнэтийн ослоос сэргийлэхээс бусад үед өгөхгүй байх, оройны 10 цагаас хойш ямар нэгэн олныг хамарсан дуу чимээ гаргуулахгүй байх ба ажлын бус цагаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг багасгах

**Дундговь аймгийн Өлзийт, Гурвансайхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих
“Баян тээгийн хайлуур жоншны ил аргаар ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	➤ Шуугианы түвшнийг зохицуулж хянаж байх, чимээ ихтэй тоног төхөөрөмж ашиглахгүй байх, ➤ Ашиглахгүй үед тоног төхөөрөмжөө заавал унтрааж байх.
Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	➤ Ундны усны хадгалалт цэвэр, эрсдэлгүй байгааг шалгаж баталгаажуулах. ➤ Хатуу/аюултай хог хаягдлын байгаль орчинд ээлтэй болон бусад менежмент хэрэгжүүлэх
Газрын гадаргад үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	➤ Барилга угсралтын үйл ажиллагаа дууссан даруйд ойр орчмыг хуучин төрхөд ойртуулан нөхөн сэргээх шаардлагатай
Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	➤ Хатуу хучилтгүй замаар зорчих үед автомашины хурдыг хязгаарлах, ➤ Салбар хооронд болон шугам сүлжээний засвар үйлчилгээний замын сүлжээг сайжруулах, ➤ Онц шаардлагагүй тохиолдолд эрүүл газар хөндөхгүй байх, ➤ Замын нэгдсэн сүлжээг бий болгох, цаашид онц шаардлагагүйгээр шинээр зам бий болгохгүй байх, ➤ Хөрс бохирдуулагч материалуудын хяналт, зохицуулалтыг сайжруулах, ➤ Тээврийн хэрэгслээс шатах, тослох материал асгарахаас сэргийлэх. Асгарсан тохиолдолд түргэн шуурхай сэргийлэх арга хэмжээ авах. ➤ Машин механизмыг зориулалтын талбайд байрлуулах, засвар үйлчилгээг мөн зориулалтын талбайд хийх, ➤ Түлш, тосолгооны материал, химийн бодис агуулах сав гэх мэт болзошгүй эх үүсвэрүүдээс асгаралт үүсэхээс сэргийлсэн хамгаалалтын суурь хийх
Ургамлын нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	➤ Тоосжилт нь ургамлын навчны амсрыг бөглөх, улмаар фотосинтезийн явцыг бууруулах, ургамлын ургалтыг доройтуулах сөрөг нөлөөтэй юм. Иймд хатуу хучилтгүй замд автомашины хурдыг хязгаарлах, замын сүлжээг сайжруулах, тоосжилтыг бууруулах усалгааг хийх, ➤ Онц шаардлагагүйгээр газар хөндөхгүй байх, ➤ Замын нэгдсэн сүлжээг нэн даруй бий болгох, цаашид онц шаардлагагүйгээр шинээр зам бий болгохгүй байх, ➤ Хөрс бохирдуулагч материалуудын хяналт зохицуулалтыг сайжруулах, ➤ Засвар үйлчилгээ, барилга угсралт болон цахилгаан дамжуулах шугамын ашиглалтын үед хэрэглэгдэх машин, механизмыг тогтмол үзлэг оношилгоонд хамруулах, ШТМ-ын асгаралт үүсгэж байгаа эсэхэд хяналт тавих, ➤ Машин механизмыг зориулалтын талбайд байрлуулах, засвар үйлчилгээг мөн зориулалтын байранд хийх ➤ Түлш, тосолгооны материал, химийн бодис агуулах сав зэрэг асгаралт үүсгэж болзошгүй эх үүсвэрүүдээс асгаралт үүсгэхээс сэргийлсэн хамгаалалтын суурь хийх
Нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах арга хэмжээ	➤ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, өндөр давтамж (85 дБА-аас дээш) тай дуу шуугиан үүсгэх ажлыг өдрийн цагаар гүйцэтгэх, ➤ Тээврийн хэрэгслүүд зорчих авто замын маршрутыг барилгын ажил эхлэхээс өмнө гаргах, ➤ Ухсан нүхийг тойруулан гэрэл ойлгогчтой тууз татах, тэмдэгжүүлэх, ➤ Тулгууруудыг суурилуулсны дараагаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг чанартай гүйцэтгэх, ➤ Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан хог хаягдлын нэгдсэн цэгт хаях, ➤ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллах, ➤ Барилгын ажлын явцад ойролцоо нутаглаж буй малчидтай нөхөрсгөөр харилцах, иргэдээс төслийн үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлтийг хүлээн авч зохих арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах зэрэг болно.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа Хайлуур жоншны ил аргаар ашиглах үйл ажиллагааны явцад байгаль орчинд ямар сөрөг нөлөөлөл үзүүлж байгааг тодорхойлсны үндсэн дээр тус төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор хүрээлэн буй орчинд, хүний эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөлөл, түүнээс сэргийлэх арга зам, анхаарвал зохих асуудлын талаар нарийвчлан төлөвлөлөө. Үүнд: Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр заавал авч хэрэгжүүлж байх арга хэмжээ, агаар, хөрс, ус зэрэг болох байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд тавих талаар хяналт шинжилгээний хөтөлбөрт тодорхой тусгаж оруулсан болно.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгах шаардлагатай байдаг.

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Энэ хэсэгт байгаль орчны судалгааны явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зардал зэргийг оруулсан болно.

Хүснэгт 9. Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, ачилт, тээвэрлэлт, овоолгоос үүссэн тоос нь орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болно.	Уурхайн технологийн замын засвар үйлчилгээг тогтмол хийж үүсэх тоосжилтын хэмжээг бага байлгах	Ил уурхай	м³	ҮА-ны зардлаар	-	ҮА-ны зардлаар	2026 он	Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолын хавсралт
2	Техник, тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах бохирдуулагч орчны агаарыг бохирдуулах	Уурхайн дотоод тээврийн болон гадаад тээврийн замд хурдны хязгаарлалтын тэмдэг тэмдэглэгээ байршуулах		Ширхэг	50.0	4	200.0	2026 он	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдөр
3	Техник, тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах бохирдуулагч орчны агаарыг бохирдуулах	Техник тоног төхөөрөмжийг тогтмол оношилгоонд оруулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлагад нийцүүлэх	Уурхайд ашиглаж буй тээврийн хэрэгсэл, техник	Ширхэг	33.0	10	330.0	2026 он	“Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилгоо явуулах журам батлах тухай” /2012 оны 12 сарын 31/ Дугаар А/199
4	Агаар орчин бохирдох	Агаар орны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэн, дүгнэлт гаргуулах зөвлөмж авах, гарсан хариуд үндэслэн арга хэмжээ авах	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан						МУ-ын Агаарын тухай хуулийн 9.1.3
5	Олборлолтын үед дуу чимээний нөлөө	шөнийн цагаар уурхайн үйл ажиллагааг хүн амьтанд хүчтэй нөлөөлөх орон зайд явуулахгүй байх	Үйл ажиллагааны зардлаас						Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2025
6		Дуу шуугианы түвшинг тодорхойлох	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан						хэмжилтийг хийхдээ Монгол улсын

**Дундговь аймгийн Өлзийт, Гурвансайхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих
“Баян тээгийн хайлуур жоншны ил аргаар ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

				стандарт MNS 5003:2000 буюу “Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага”-
НИЙТ ЗАРДАЛ			530.0 мян.төг	

Хүснэгт 10. Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян. төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Усыг заасан хэмжээнээс хэтрүүлж ашиглах	Ус ашиглуулах дүгнэлтийг холбогдох газраар гаргуулж, заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй ашиглах	Уурхайн талбай	ҮА-ны зардлаар				2026 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Усны тухай хууль MNS 6148:2010 Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2	Ус ашиглах эх үүсвэрийг бохирдохоос хамгаалах	Гүний худагт эрүүл ахуйн болон хамгааллын бүс тогтоож хашаажуулан дэглэмийг мөрдөж ажиллах	Гүний худаг	Ширхэг	200.0	1 ш	200.0	2026 он	
3	Усны хэрэглээ, ашиглалт ихсэх, усны түвшин буурах	Гүний худагт тоолуур суурилуулах		Ширхэг	250.0	1 ш	250.0	2026 он	Усны тухай /Шинэчилсэн найруулга/ 12.1.4
4	Усны бохирдол	Газар доорх усны хяналт шинжилгээг малчдын худгууд дээр хуваарийн дагуу хийж гүйцэтгэх	Төслийн талбай орчмын 2 худаг	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан				2026 он	
5		Булгийн эх ба уст цэгүүдийг цэвэрлэх арга хэмжээ зохион байгуулах		Хүн/өдөр	200.0	1	200.0	2026 он	
НИЙТ ЗАРДАЛ					650.0 мян.төг				

**Дундговь аймгийн Өлзийт, Гурвансайхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих
“Баян тээгийн хайлуур жоншны ил аргаар ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Хүснэгт 11. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хөрсөнд шатах тослох материал алдагдах, өнгөн хөрс бохирдох	Түлш, шатах тослох материалаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх асгаралтын үед ашиглах бэлдэцтэй болох	Төслийн талбай	Ширхэг	100.0	1	100.0	2026 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай /2012 оны 05 дугаар сарын 17/ 8.4.1
2	Төлөвлөгдөөгүй замаар тээвэр хийж олон салаа зам гаргаж өнгөн хөрс доройтуулах	Ашиглалтын талбайд олон салаа зам үүсэхээс сэргийлж тэмдэг тавих, хаалт хийх	Төслийн талбай	Ширхэг	100.0	2	200.0	2026 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай /2012 оны 05 дугаар сарын 17/ 6 дугаар зүйл 6.1.6
3	Хөрсний бохирдол үүсэх	Эко 00 суурьлуулах	Уурхайн карьерт	Ширхэг	ҮА-ны зардлаар			2026 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай /2012 оны 05 дугаар сарын 17/
4	Ахуйн болон бусад энгийн хог хаягдлаар хөрс бохирдох	Хогийн цэгийг тохижуулах	Уурхайн түр хогийн цэг	Ширхэг	500.0	1	500.0	2026 он	Байгаль орчныг хамгаалах тухай хууль “Хог хаягдлын тухай” хууль Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5850:2019
5	Хөрсний бохирдол	Хөрсний төлөв байдал ба бохирдлын мониторинг судалгаа хийж хэрэгжүүлэх	Уурхай орчмын бүс	ОХШХ-т тусгагдсан				2026 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай /2012 оны 05 дугаар сарын 17/
НИЙТ ЗАРДАЛ					800.0 мян.төг				

Хүснэгт 12. Ургамал, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
---	-----------------------------------	---	-------------------------------	-------------	-------------------------	------------	-----------------------	------------------------------	---------------------------------

**Дундговь аймгийн Өлзийт, Гурвансайхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих
“Баян тээгийн хайлуур жоншны ил аргаар ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

1	Ургамлын доройтол	Ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх	Төслийн талбай	Мян.төг	-	Жилд 1 удаа	500.0	2026 он	Ургамал хамгааллын тухай /Шинэчилсэн найруулга/ 2007 оны 11 дүгээр сарын 15 өдөр	
2		Олон салаа зам гаргахгүй байх, тогтмон маршрутын дагуу тээвэрлэлт хийх	Уурхайн орчмын талбай	Хөрс хамгаалах арга хэмжээнд оруулсан					БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-318 дугаар тушаалын хавсралт “УУ-н үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал Эвдэрсэн газрыг ургамалжуулах”	
3		Тоосны хуримтлал үүсэж ургамлыг устгах аюултай тул зам талбайг тогтмол услах	Уурхайн олборлолт явуулж байгаа талбай	ҮА-ны зардлаар				2026 он		
4		Төслийн хэрэгжилтээс үүдэлтэй хог хаягдлыг ангилан ялгах, цэгийг бий болгох	Төслийн хогийн цэг болон хогийн цэгүүд	Ширхэг	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.					2026 он
5	Зэрлэг амьтад уурхайн бүсэд нэвтрэх	Зэрлэг амьтад болон мал уурхайн бүсэд нэвтэрч уурхайд унаж бэртэхээс хамгаалах хашаа барих	Уурхайн талбай	м	10,000,000.00				2026 онд	БОНБУ-ний амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж
НИЙТ ЗАРДАЛ					10,500.0 мян.төг					

4.2. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 13. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Уурхайн ажлын явц дахь болзошгүй осол	Аюулгүйн тууз татах, хашаажуулах	Уурхайн орчинд	Үйл ажиллагааны зардал			2026 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай /2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр/
2	Шатах тослох материал шатах эрсдэлээс сэргийлэх	Шатах тослох материалыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалах		ҮА-ны зардлаар			2026 он	Газрын тосны бүтээгдэхүүний тухай

**Дундговь аймгийн Өлзийт, Гурвансайхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих
“Баян тээгийн хайлуур жоншны ил аргаар ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

3	Шатах тослох материалын асгаралт	Засварын талбайд хайрган хучилт хийх		ҮА-ны зардлаар			2026 он	/2005 оны 7 дугаар сарын 1-ны өдөр/
4	Химийн бодисын хадгалалт, тээвэрлэлтийн явцад учрах эрсдэл	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын сургалт хийх.	Уурхай болон кемп орчин	ҮА-ны зардлаар			2026 он	Химийн хорт болон аюултай бодисын тухай /2006 оны 5 дугаар сарын 25-ны өдөр/
5		Химийн бодисын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт, устгалд хяналт тавих.		6	50.0	300.0	2026 он	
6		Химийн хорт болон аюултай бодисын тооллого хийх.		10	30.0	300.0	2026 он	Химийн хорт болон аюултай бодисын тухай /2006 оны 05 дугаар сарын 25-ны өдөр/
7	Химийн бодисын ашиглалтаас үүсэх болзошгүй эрсдэл	Ажлын байранд ашиглаж байгаа химийн бодисуудын ХАЛМ-ийг ажлын байрнуудад байрлуулах		30	10.0	300.0	2026 он	
8	Газрын хөрс, барилга байгууламж эвдрэх, үерийн усанд автах	Ил уурхайн гадуур хамгаалалтын далан хийх, засаж сайжруулах	Уурхайн кемп	ҮА-ны зардлаар			2026 он	“Гамшгаас хамгаалах тухай” /Шинэчилсэн найруулга/ 2017 оны 02 сарын 02 өдөр
9	Хээрийн түймэр гарах	Гал унтраах хэрэгслээр хангах, ажилчдад гал унтраах сургалт хийж байх. Тэсэрч дэлбэрч болох материалын хадгалалт болон асгаралтыг хянаж байх, асгарсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авах.	Уурхай орчмын талбай болон уурхайн бүс	ҮА-ны зардлаар			2026 он	“Ой хээрийн түймэр унтраахад оролцуулах тухай” 2017 оны 7 дугаар сарын 17 өдөр Дугаар-09
НИЙТ ЗАРДАЛ						900.0 мян.төг		

4.3. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө

2026 онд Уулын ажлын төлөвлөгөөний дагуу хөрс хуулалт, олборлолтын ажил хийж гүйцэтгэх бөгөөд уг ажлын дагуу үржил шимт хөрс хуулах, тээвэрлэх, хадгалах зэрэг байгаль хамгаалах ажил хийгдэх бөгөөд эдгээр ажлыг нөхөн сэргээлтийн ажилд оруулж тооцон нийт 12,000,000.00 (Арван хоёр сая) төгрөг тооцож төсөвлөв.

4.4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Их газрын чулууны байгалийн цогцолборт газарт биотехникийн аргэ хэмжээ авах бөгөөд нийт зардлын хэмжээ 4,200,000.00 (Дөрвөн сая хоёр зуун мянга) төгрөг байна. Үүнд:

1. Хужир, мараа давс тавих
2. Аргаль, янгирт зориулан өвс тавих.

4.5. Тэрбум мод үндэсний хөдөлгөөн

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Дундговь аймгийн Гурвансайхан сумын төвд 2026 онд нийт 200.0 хайлаас тарина. Уг ажлын хүрээнд хашаажуулах, мод тарих ажилд нийт 5,000,000.0 (Таван сая) төгрөг төсөвлөв.

4.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар археологийн болон палеонтологийн олдвор одоогоор илрээгүй байгаа бөгөөд цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн Хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” хэмээн заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөн ажиллах нь зүйтэй.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь төслийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны яамны тусгай зөвшөөрөлгүйгээр зааж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын тухай хуулийн зорилт нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, хүрээлэн буй орчныг цэвэрлэх, устгах харилцааг зохицуулахад оршино.

Хүснэгт 14. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хатуу хог хаягдлыг тогтмол	Ахуйн хатуу хаягдлыг 11, үйлдвэрийн хог хаягдлыг 7 ангилан ялгах бүхий хог хадгалах цэгийг байгуулах	Үйл ажиллагааны турш	ш	500,000.0	1	500,000.0		Хог хаягдлын тухай хууль болон

**Дундговь аймгийн Өлзийт, Гурвансайхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих
“Баян тээгийн хайлуур жоншны ил аргаар ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

2	зайлуулаа гүй гээс орчин бохирдох	Дээрх ангиллын дагуу анхдагч эх үүсвэр дээр хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийж 2 газарт байрлуулах		ш	200,000.0	2	400,000.0	2026онд	холбогдох журам, заатлууд
		Аюултай хог хаягдлыг стандартын дагуу зайлуулж устгуулах	Үйл ажиллагааны турш	удаа	Байгууллага хоорондын гэрээгээр				
3		Сумын хог хаягдлын цэгт хог тээвэрлэх зардал болон хогийн хураамж	Үйл ажиллагааны турш	Сард 1 удаа	Сумын ИТХ-аас баталсан хог хаягдал зайлуулах үнийн дагуу				
4									
5		Дахивар хог хаягдлуудыг зохих цэг тээвэрлэх зардал	Үйл ажиллагааны турш	Жилд 2 удаа	500,000.0		500,000.0		
НИЙТ ЗАРДАЛ					1,400.0 мян.төг				

4.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тухайн төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн байгаа орчны бүрэлдэхүүн хэсэг (агаар, хөрс, усан орчин)-т сөрөг нөлөөлөл, өөрчлөлтийг үзүүлж байгаа эсэхэд хяналт тавих, бохирдлыг хянах боломж бүрдэнэ.

Хүснэгт 15. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Зардал, мян.төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
1.	Хүхэрлэг хий (SO ₂)	Төслийн талбайд 2 цэг сонгоно	2	1	600.0	MNS 4585:2016
2.	Азотын давхар исэл (NO ₂)					
3.	PM _{2.5} , PM ₁₀					
4.	Дуу чимээ					
5.	Хүнд металлын үзүүлэлт	Төслийн талбайд хоёр цэгийг сонгоно /машины түр зогсоол, ногоон байгууламж/	2	2	200.0	MNS 5850:2019
6.	Хөрсний физик химийн шинж чанар	Төслийн талбайд хоёр цэгийг сонгоно	2	4	200.0	MNS 3297:2019
7.	Ундны усны чанарын үзүүлэлт	Усны хими, физик шинж чанар	2	1	200.0	MNS 090: 20218
8	Бохир ус	Усны хими, физик шинж чанар	4	1	800.0	MNS 6561:2015
НИЙТ ЗАРДАЛ					2,000.0 мян.төг	

4.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 16. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцоолсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан/ ажилтан	Баримтлах стандарт, арга аргачлал
			2026					
		Улирал	1	2	3	4		
1	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар ажил эхлэхийн өмнө сургалт, сурталчилгааг хийх	400 000					ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай /2008 оны 5 дугаар сарын 22 өдөр/
2	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбар гаргаж, шинэчилж байх	400 000					ХАБЭА	Байгаль орчныг хамгаалах тухай /1995 оны 3 дугаар сарын 30 өдөр/
3	Гал тогооны хэсэгт ажиллах хүн бүрийг жилд 2 удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	ҮА-ны зардлаар					ХАБЭА	Эрүүл ахуйн тухай /2016 оны 2 дугаар сарын 4 өдөр/
4	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөр хамгаалал, хориглосон үйл ажиллагааны таниулах самбар байгуулах	ҮА-ны зардлаар					Байгаль орчны ажилтан	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай /2008 оны 5 дугаар сарын 22 өдөр/
5	Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах	ҮА-ны зардлаар					Байгаль орчны ажилтан	Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам Дугаар 75 /2023 оны 11 дүгээр сарын 10 өдөр/
6	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон биелэлтийн тайланг боловсруулахдаа байгаль орчны мэргэжлийн байгууллагын зөвлөгөө авах	Үйл ажиллагааны зардлаас					Байгаль орчны ажилтан	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө Дугаар А/618 /2019 оны 10 дугаар сарын 29 өдөр/
8	Тэрбум мод хөтөлбөрийг дэмжих	2 000 000					Байгаль орчны ажилтан болон мод тарих мэргэжлийн байгууллага	Дундговь аймгийн Гурвансайхан сумын төвд тарих модны арчилгаа, хяналтад гэрээт ажилтан ажлуулна.
НИЙТ ЗАРДАЛ							2,800.00 мян.төг	

4.10. Нөлөөллийн бүсийн иргэдэд тайлагнах ажлын төлөвлөгөө

Хүснэгт 17. Нөлөөллийн бүсийн иргэдэд тайлагнах ажлын төлөвлөгөөний зардал

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан ажиллах байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Нөлөөллийн бүсийн иргэдийг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний	Бичгэн болон илтгэл хэлбэрээр	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан	10-р сарын 20-наас өмнө	200,000	Байгаль орчны мэргэжилтэн болон компаний гүйцэтгэх захирал	Гурвансайхан сумын Дэрсэн ус багийн төвд

**Дундговь аймгийн Өлзийт, Гурвансайхан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих
“Баян тээгийн хайлуур жоншны ил аргаар ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

2	биелэлтийг танилцуулах			10-р сарын 25-наас өмнө	200,000	Байгаль орчны мэргэжилтэн болон компаний гүйцэтгэх захирал	Өлзийт сумын Буянт-2 багийн төвд
3	БОУАӨЯ, Дундговь аймгийн БО-ны газар, Сумдын байгаль орчны байцаагч	Бичгээр		10-р сарын 30-наас өмнө	200,000	Байгаль орчны мэргэжилтэн	Аймгийн байгаль орчны газар
Нийт						600.0 мян.төг	

Төслийн 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардлыг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 18. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Гүйцэтгэх хугацаа	Нийт дүн
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг	2026 он	12,480,000.0
2	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	Төгрөг		12,000,000.0
3	Дүйцүүлэх хамгааллын зардал	төгрөг		4,200,000.0
4	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	төгрөг		-
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	төгрөг		900,000.0
6	Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	төгрөг		2,800,000.0
7	“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд сумын төвд мод тарих	төгрөг		5,000,000.0
8	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	төгрөг		1,400,000.0
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	төгрөг		2,000,000.0
10	Нөлөөллийн бүсийн иргэдэд тайлагнах ажлын зардал			600,000.0
НИЙТ ДҮН				41,380,000 мян.төг

